



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас:26-04-37, Факс:51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ДАРГА
О.СУМЬЯАСҮРЭН ТАНАА

2022.03.25 № 01/408

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөө, аж ахуйг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр байсан.

Хөдөө, аж ахуйг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Татгалзсан дүгнэлтийн үндэслэл

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

Тус сангаас аудитад ирүүлсэн санхүүгийн тайлан иж бүрэн бус, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл баталгаажуулахгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлагнаж ирүүлээгүй, авлага, өглөгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, нягтлан бодох бүртгэлийн программын мэдээллүүд дутуу, зээлдэгчийн овог, нэр, регистрийн дугаар, зээлийн дүн зөрүүтэй, эзэн холбогдогч тодорхойгүй байгаа учир анхан шатны баримттай тулган баталгаажуулах боломжгүйн улмаас санхүүгийн тайлангууд бүхэлдээ буруу илэрхийлэгдсэн байна.

Дээр дурдсан шалтгааны улмаас аудитын горим, сорил хэрэгжүүлж, санхүүгийн тайлангууд болон тодруулгууд нь үнэн зөв, шударга бэлтгэж, толилуулсан гэх аудитын хангалттай, зохистой нотолгоо олж авч чадаагүй, үүссэн тодорхой бус байдлуудын үр дагавар ба санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй хуримтлагдсан үр нөлөөг тогтоох боломжгүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Тусгай сангийн тухай хууль, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ